

## 3

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

## 3.1. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ХЭНТИЙЧҮҮД

● 6-9 ДҮГЭЭР АНГИЙН НИЙТ СУРАГЧДЫН 70 ХУВЬ НЬ  
"НОГООН ПАСПОРТ"-ТОЙ БОЛЛОО

Засгийн газрын 2018 оны 209 дугаар тогтоолоор "Тогтвортой хөгжлийн боловсрол" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд ханган ажиллаж, аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж хүүхэд, залуучууд, олон нийтэд байгаль орчиндоо ээлтэй хандах хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр 38 удаагийн нэвтрүүлэг, шторк, ярилцлага, нийтлэл бэлтгэжээ. Мөн аймгийн ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн нийт сурагчдын 70 хувь нь "Ногоон паспорт"-той болж, хүүхэд өсвөр үеийнхнээр дамжуулан байгальд ээлтэй арга хэмжээг үе шаттай зохион байгуулж ажиллалаа. Аймгийн хэмжээнд 10 сургууль, 1 коллеж "Эко сургууль", 20 цэцэрлэг "Эко цэцэрлэг"-ийн болзол хангаж нийт 4 "Мөнгөн гэрэгэ", 27 "Хүрэл гэрэгэ" гэрчилгээ аваад байна. Экологийн боловсролын олимпиадыг жил бүр зохион байгуулж, "Эко сургууль", "Эко цэцэрлэг" шалгаруулах аян, байгальд ээлтэй эко сум 2, байгууллага 1-ийг болзолт уралдаан зарлаж шалгаруулжээ.



## ● 24 БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МОТОЦИКЛООР ХАНГАЖЭЭ

Байгаль орчны салбарын ажилтнуудын ажиллах боломж нөхцөлийг сайжруулж, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэх, Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангаж, байгалийн нөөц баялгийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2017 онд 5, 2018 онд 12, 2019 онд 7, нийт 24 байгаль хамгаалагчийг мотоциклоор хангаж, Байгаль хамгаалах салбарын албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах сургалтыг 21 удаа зохион байгуулж нийт 512 албан хаагчдыг хамруулан хоёр байгаль хамгаалагчид Улсын байцаагчийн эрх олгожээ.



## ● 37.5 ГА НОГООН БАЙГУУЛАМЖТАЙ БОЛЛОО

2019 онд аймгийн хэмжээнд "Бүх нийтээр мод тарих аян"-ны хүрээнд 2,4 мянган мод тарьж нийт 6 га талбайд ногоон байгууламж нэмэгдүүлжээ. Тухайлбал, 2017 онд 3 га, 2018 онд 6.5 га, 2019 онд 6 га, нийт 15.5 га талбайд тус тус ногоон байгууламжийг нэмэгдүүлж нийт 37.5 га ногоон байгууламжтай боллоо. 2017 онд Өндөрхаан хот тохижилт ОНТҮГ-ыг түшиглэн "Хотын ногоон байгууламжийг хариуцсан тасаг"-ийг байгуулж, гүн өрмийн 1 худаг шинээр гаргаж, 2018 онд усалгааны автомашинтай болж, 2019 онд усалгааны систем авч, үйл ажиллагааг сайжруулах үүднээс тус тасгийн урсгал зардлыг төсөвт суулган санхүүжүүлж байна.





## ● СУМ ДУНДЫН ОЙН АНГИУДАД БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АВТОМАШИН ГАРДУУЛЛАА

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/223 тоот тушаалаар 4 сум дундын ойн ангид /СДОА/ 17 ширхэг үлээгч аппарат, 17 ширхэг үүргэвчит гал унтраагч, 24 ширхэг Хөдөлмөр хамгааллын хувцас, 16 ширхэг хуванцар усны сав өгч багаж төхөөрөмжөөр хангасан ба БХНСЗ-ын



10.0 сая төгрөгөөр Ойн хөнөөлт шавьж устгалд ашиглах багаж, БОАЖЯ-с 2 СДОА-д УАЗ ФУРГОН шинэ автомашин олгосон. 2018 онд "Биндэр -Ой" СДОА-г түшиглэн FAO төслийн санхүүжилтээр ойн цэвэрлэгээний ажлаар бэлтгэсэн модыг боловсруулах, зохистой ашиглах зорилгоор Мужааны цех шинээр байгуулж шаардлагатай бүх тоног төхөөрөмжөөр хангалаа. Түүнчлэн сумын болон Сум дундын ойн ангийн 18 албан хаагч Хятад улсын Хайлаар хотын ногоон байгууламж, мод үржүүлгийн газартай танилцах, туршлага судлах аялалд хамрагдлаа.

## ● ОЙН МЕНЕЖМЕНТ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА



Улсын төсвийн хөрөнгөөр /УТХ/ Дадал суманд 40 га, Өмнөдэлгэр суманд 20 га, БХНСЗ-аар Батширээт суманд 20 га, Өмнөдэлгэр суманд 20 га, ойн мэргэжлийн байгууллага, ойн ангиуд өөрийн хөрөнгөөр 37, "Мод дагаж ус -Ус дагаж амьдрал" аяны хүрээнд 13 га, нийт 150 га талбайд ойжуулалт хийгдлээ. Мөн УТХ-өөр Батширээт, Норовлин суманд тус бүр 25 га, Биндэр, Дадал, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдад тус бүр 50 га, Цэнхэрмандал суманд 20 га нийт 270 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийгдлээ. Ойжуулалтын хэмжээ

өмнөх оноос 53 га-аар, нөхөн сэргээх ажил 240 га-аар тус тус нэмэгдлээ.

## ● 15 ГА ОЙН ЗУРВАС БАЙГУУЛЖ, ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ШОРООН ЗУРВАСЫГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ



Ойн зурвас байгуулах замаар цөлжилтийн эрчмийг сааруулах зорилгоор 2017-2019 онд Цэнхэрмандал суманд 0.5 га, Галшар суманд 1 га, Хэрлэн сумын Хүндэтгэлийн хаалганы дэргэд 3.5 га, "Гэлэн хөшөө"-ний орчимд 2.5 га, нийт 7.5 га талбайд ойн зурвас байгуулжээ.

Мөн 2017 онд 10 м-ийн өргөнтэй нийт 131 км шороон зурвасыг шинээр байгуулж, 175 км урт, 10 м-ийн өргөнтэй түймрээс хамгаалах шороон зурвасыг шатаах аргаар арчлан сэргээсэн ба 2018 онд 30 км урттай газрыг 10 метрийн өргөнтэй,

28 км газрыг 20 метрийн өргөнтэйгөөр шинээр хагалж зурвасын өргөний хэмжээг нэмэгдүүлжээ. Харин 2019 онд 86 км урттай газрыг 10 метрийн өргөнтэй хагалж арчлан сэргээсэн байна.

2018 онд нийт 9 удаагийн, 2019 онд 7 удаагийн ой хээрийн түймэр бүртгэгдэж, түймрийн гаралт өмнөх оноос 30 хувиар буурчээ.



## ● ХОГНЫ ШИНЭ МЕНЕЖМЕНТ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

2017-2018 онд Хэрлэн гол дагуу нийтдээ 17 ш хогийн сав байрлуулж, Аюултай хог хаягдлын байгууламж барих цэгийг тогтоожээ. Үүнчлэн Хэрлэн сум, Бэрх тосгон, Баян-Адрага сумын хогны төвлөрсөн цэгийг шинэчлэх, хуучин төвлөрсөн хогийг түрэх, дарж булшлах байдлаар орчныг бохирдлыг бууруулж,

шинээр машин механизм, тоног төхөөрөмж худалдан авч нэмэх замаар менежмент зохион байгуулалтын ажлуудыг хийлээ. Хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах чиглэлээр хэд хэдэн туршилт үйл ажиллагааг хэрэгжүүлж нэвтрүүлээд байна.

### ● ЧИНГИС ХОТЫН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙГ ХАМГААЛЖ, ХЭРЛЭН ОНОН ГОЛЫН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙГ ТЭМДЭГЖҮҮЛЭЛТ ХИЙЛЭЭ



Хэрлэн сумын Хэрлэн голын орчимд ашиглагдаж байгаа ундны усны эх үүсвэрийн 6 худгийг хашиж, 3 худгийг камержууллаа. Хэрлэн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн 43 ширхэг тэмдэгжүүлэлт бүхий самбар, 2019 онд Онон голын онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсэд 50 ширхэг самбарыг тус тус байршууллаа.

Түүнчлэн усны чанарын хяналтын тогтолцоог бий болгож, сумын төвүүдийн хүн амын ундны усны эх үүсвэрт ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж шинээр суурилуулах зорилгоор 2017-2019 онд 5 сумын 5 худаг, нэг төсөвт байгууллагад ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулж 2017-2019 онуудад давхардсан тоогоор 18 суманд 38 булгийн эхийг хашиж, сэргээн заслаа.

### ● АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН 43.03 ХУВЬ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВЛАА



2019 онд Улсын тусгай хамгаалалтад 9 газрын 1087186,709 га талбай буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 13.5 хувь, орон нутгийн хамгаалалтад 430 газрын 2369980.68 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 29.5 хувь, нийт 439 газрын 3457167.389 га аймгийн нутаг дэвсгэрийн 43.03 хувь хамрагдаж байгаа ба өмнөх оноос 3.1 хувиар өссөн байна. Мөн Улсын тусгай хамгаалалттай Онон Балжийн байгалийн цогцолборт газрын өргөтгөлийн 334921.6 га, Орон нутгийн хамгаалалттай

Хурх хүйтний хөндийн 549581.87 га, Гутайн даваа-Хөмүүл голын эхийн 103173 га газрын тус тус Улсын тусгай хамгаалалтад авахаар дээд шатны байгууллагад уламжилжээ.

### ● НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР...

- 2018-2019 онд уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газар 38.4 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлээ.
- 2017-2019 онд давхардсан тоогоор 28 аж ахуй нэгжийн 66.08 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 44.81 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж аваад байна.
- 2019 оны байдлаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу 13 аж ахуй нэгж 1365.79 га талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.
- 2019 онд Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу 8 суманд 58 нөхөрлөл байгуулагдаж, 239.08 га талбайд үйл ажиллагаа явуулж байна.





## 3.2. БАХАРХАХ ЗҮЙЛТЭЙ ХЭНТИЙЧҮҮД

### ● "ЧИНГИС ХААН БРЭНД" ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАН ЖУУЛЧДЫГ ТАТАЖ ЭХЭЛЛЭЭ



"Чингис хаан брэнд" дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 17 дугаар хуралдаанаар батлуулж, жил бүр "Тогорууны баяр", "Ёохор наадам", "Чингис фестиваль", "Галшар адууны баяр", "Монгол тайга нохойн наадам", "Талын түмэн адуу" зэрэг аялал жуулчлалын эвент арга хэмжээ зохион байгуулж, 2017 онд дотоодын 3500 орчим, гадаадын 320 жуулчин оролцсон бол 2019 онд 6 эвент арга хэмжээнд дотоодын 7000, гадаадын 600 орчим жуулчин оролцсон нь 50 хувиар нэмэгджээ.

### ● ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗАР БОЛОН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛЭЭ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ТҮГЭЭЖ БАЙНА



Хэнтий аймгийн түүх, соёлын дурсгалт газар болон аялал жуулчлалтай холбоотой мэдээллийг АЗДТГ-ын [www.khentii.mn](http://www.khentii.mn) веб сайтад оруулахаас гадна Байгаль орчин, аялал жуулчлалын газрын [www.nature.khe.gov.mn](http://www.nature.khe.gov.mn) веб сайтад тогтмол нийтэлж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын веб сайтад 2019 оны 11 сарын байдлаар 366654 хүн нэвтэрч мэдээлэл авчээ.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйл ажиллагааг цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилснаар зорин ирэх жуулчид 30 хувиар нэмэгдэж, Цахим мэдээллийн хэрэгслийн хандалтын тоо 20 дахин өсжээ.

### ● ХЭНТИЙ АЙМАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ИТМ-2019 ҮЗЭСГЭЛЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Байгаль орчин аялал жуулчлалын яам, Монголын аялал жуулчлалын холбооноос жил бүр зохион байгуулдаг Ай Ти Эм /ИТМ/ Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 20 дахь жилдээ 2019 оны 3-р сарын 29, 30, 31-ний өдрүүдэд "Мишээл Экспо" үзэсгэлэнгийн төвд зохион байгуулагдлаа. Үзэсгэлэнгийн үеэр Хэнтий аймаг Монголын аялал жуулчлалын холбооны 2020 оны түнш аймгаар сонгогдож шилжин явах тугаа гардан авлаа. Хамтран ажиллах санамж бичигт аймгийн Засаг дарга Н.Ганбямба, МАЖХ-ны ерөнхийлөгч Д.Гантөмөр нар гарын

үсэг зурсан юм. Ингэснээр Хэнтий аймгийг бүтэн жилийн турш олон улсад сурталчлах, томоохон эвент арга хэмжээг хамтран зохион байгуулж жуулчдыг татах, гадаад харилцааг өргөжүүлэх юм. Тус үзэсгэлэнг 20 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд Монгол, Япон, Тайланд, ОХУ-ын Буриад, Тува, БНХАУ-ын ӨМӨЗО болон 21 аймгийн аялал жуулчлал, тээвэр, зочлох болон үзвэр үйлчилгээний 320 гаруй байгууллага бүтээгдэхүүн үйлчилгээ, дэвшилтэт технологи, шилдэг инновацийг танилцуулж оролцсон ба Хэнтий аймгаас Батширээт суманд үйл ажиллагаа явуулдаг Чингисийн өлгий, Онон Ёл, Ивээлт хайрхан баазууд "Ёохор наадам" аялал жуулчлалын эвент арга хэмжээгээ сурталчлан оролцлоо. Дадал сумаас Чингисийн гурван нуур, Алтаргана, "ДМД" жуулчны баазууд, Биндэр сумаас Чингисийн тоонот жуулчны бааз, Дэлгэрхаан сумаас "Хилчин", "Эвтэй дөрвийн өргөө" амралтын газар, Дадал сумын гар урчууд хийсэн бүтээлээ танилцууллаа.

● **16-Р СЭЦЭН ХАН АРТСЭДИЙН ТҮҮХИЙГ ӨГҮҮЛСЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ПАРК БАЙГУУЛНА**



Чингис хотод 16-р Сэцэн хан Энхтөрийн Артсэдийн түүхийг сэргээн алдаршуулах мөнхжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/402 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж судалгааны ажлаа эхлүүлж, улмаар 2018 онд “Аялал жуулчлалын парк-ын зураг төсвийг боловсруулсан. Энэ онд 16-р Сэцэн хан Энхтөрийн Артсэдийн гудамжинд аялал жуулчлалын парк байгуулах зорилгоор орон нутгийн төсвөөс 200 сая төгрөгийн санхүүжилтийг гарган

паркийг хашаажуулаад байна. Ирэх 2020 онд паркийг тохижуулах ажлыг төлөвлөжээ.

● **ХЭНТИЙ НУТГААС ТӨРӨН ГАРСАН 9 АЛДАРТНЫГ АЛДАРШУУЛАВ**



Ж.Болдбаатарын нэрэмжит “Хүндийн өргөлтийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн”, Өсвөр үеийн хүндийн өргөлтийн нээлттэй тэмцээн, Монгол улсын гавьяат багш Д.Ренчиний нэрэмжит “Ахмад мастеруудын спортын 5-р их наадам”, соёлын чиглэлээр Монгол улсын уртын дуучин, ардын жүжигчин Ч.Шархүүхэний нэрэмжит “Монгол ардын уртын болон богино дуулаачдын улсын уралдаан”, МУУГЗ, нэрт бүжиг дэглээч Д.Санжаасүрэнгийн нэрэмжит “Зүүн болон

говийн бүсийн мэргэжлийн болон сурагчдын бүжгийн уралдаан”, боловсролын ахмад 3 багш, Монгол улсын гавьяат эмч Я.Дарьбазарын алдрыг тус тус тэмдэглэж, Хэнтий нутгаас төрөн гарсан 9 алдартныг алдаршуулж, нэрэмжит тэмцээнийг нь улсын хэмжээнд зохион байгууллаа.

● **ХУРДАН АДУУНЫ ҮҮЛДЭР УГШЛЫГ СУДЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ**



Галшар, Онон мөр адуу, Мөрөнгийн хурдан удмын адуу, Сэцэн ханы Хан угшил, Дайчин засаг, Дархан вангийн хурдан удмын адууны үүлдэр угшлыг судлах судалгааны ажлыг гүйцэтгэх хамтарсан ажлын хэсгийг байгуулан судалгааны ажил 2017 оноос эхлэн хийж эхэллээ.





## МОНГОЛЫН АНХНЫ БААТРЫН ГЭРЭЛТ ХӨШӨӨ СҮНДЭРЛЭЛЭЭ

Богд Найрамдах Монгол Ард Улсын анхны баатар, хурандаа Шагдарын Гонгорын дурсгалд зориулсан гэрэлт хөшөөний нээлтийн ёслолын үйл ажиллагаа өнөөдөр Хэнтий аймгийн төвд боллоо. Нээлтэнд Батлан Хамгаалахын дэд Т.Дуламдорж, Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямба, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, хурандаа Ө.Эрдэнэ-Очир, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газрын дарга Г.Эрдэнэбат болон ахмад дайчин, Хэнтий аймгийн нутгийн ард иргэд оролцлоо.



Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямба “Өнөөдөр Ардын журамт цэргийн ахмад Партизан Б.Пунцагийн хөшөөний дэргэд анхны баатрынхаа хөшөөг босголоо. Хэнтий аймаг бол Халх голын дайны ар тал, хангалтын үйлчилгээний томоохон бааз суурь байсан. Хүнс хоол төдийгүй, цэрэг зэвсгийн хүчээр хангаж, Халх голын дайнд томоохон үүрэг гүйцэтгэсэн ард бол Хэнтийчүүд. Манай аймагт 1937 онд барьсан анхны цэргийн зөвлөлийн байшин бий. Хэнтийчүүд маань Улсын анхны баатартай гэдгээрээ бахархдаг. Өнөөдөр бол Хэнтийчүүд төдийгүй нийт Монголчуудын түүхэн өдөр.” гэлээ.



Шагдарын Гонгор нь Хэнтий аймгийн Баянхутаг сум буюу тухайн үеийн Идэрмэг сумын нутагт 1912 онд төрсөн.

Тэрээр 1933 оноос цэрэг, тасгийн захирагч, салаан захирагчийн туслахаар алба хааж, 1943-1944 онд ЗХУ-д М.Фрунзийн нэрэмжит цэргийн академид суралцаж төгссөн. 1936 оны I сарын 28-ны шөнө 6-р дивизийн харьяа Буландэрсний харуулаас зүүн хойшоо 7км-т орших Цагаан-Ухаа дээр гарч байсан манаанд салааны туслах дарга Ш.Гонгор хоёр цэргийн хамт үүрэг гүйцэтгэж байв. 21 цаг 40 минутын үед дайсны зэвсэгт арван морьтой хүн явгалан манаа руу давшин буудахад Гонгор нэг цэргийг холбоо, нөгөөгөөр нь морьдоо бариулж ганцаараа 2 цаг тулалдаж дайсны цэргийн заримыг устгаж, буу зэвсгийг нь олзлон авч, бусдыг нь хөөж гаргажээ.



1939 онд Халх голын тулалдаанд Хуягт бригад командлан оролцсон. 1943 онд “Хувсгалт Монгол” танкийн бригад, “Монгол Ард” эскадрилийг хүлээлгэн өгөх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчөөр явжээ. 1946 оноос цэргийн албанаас халагдан олон нийтийн байгууллагад ажилласан. БНМАУ-ын Улсын баатар – Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн (УБХТ) 1936 оны I сарын 29-ний өдрийн 4-р тогтоолоор Цэргийн гавьяаны I зэргийн одон болон бусад медалиудаар шагнагдаж байжээ. Улсын баатар Ш.Гонгор нь 1992 онд 80 насандаа таалал төгсжээ. 2019.08.25.

